



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№63 /507/

2023.04.18

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ, ЯПОН ЦЭРГИЙН ИНЖЕНЕРҮҮДИЙН ХАМТАРСАН "ЗАМ-2023" СУРГАЛТ, ДАДЛАГА ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний цэргийн инженерүүдийн хамтарсан "Зам-2023" сургалт, дадлагын нээлтийн үйл ажиллагаа өнөөдөр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд БХЯ-ны ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки, Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ирики Ёохэй болон "Зам-2023" сургалт, дадлагад хамрагдах Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний 30 гаруй цэргийн инженерүүд оролцлоо.

Арга хэмжээг нээж ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах хэлсэн үгэндээ "2014 оноос

уламжлал болгон зохион байгуулж буй уг сургалт, дадлагын үр дүнд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн инженерүүд олон улсын стандартад нийцсэн өндөр түвшний автозамыг барих чадвартай болсон. Иймд Монгол Улсын Зэвсэгт хүчин, НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд "Инженерийн рот"-оо үүрэг гүйцэтгүүлэхээр бэлтгэж ажлаа хангаж буйг хэлэхэд таатай байна" хэмээсэн юм.

Үргэлжлүүлэн Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Кобаяши Хироюки хэлсэн үгэндээ "Өнгөрсөн оны 11 дүгээр сард Япон Улсын Ерөнхий сайд Ф.Кишида, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх нар хамтарсан мэдэгдэл хийх үеэрээ Япон, Монголын харилцааг "Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн

түншлэл" болгон шинэчлэн баталж, зөвхөн хоёр орны харилцааг бэхжүүлэх төдийгүй бус нутаг, олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын ажиллагааг дамжуулан дэлхийн нийтийг хамарсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахаар санал нэгдсэн. Үүнтэй холбогдуулан Япон Улсын Засгийн газар НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд инженерийн цэргийг томилон ажиллуулах Монгол Улсын зорилтыг дэмжих зорилгоор уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Өнөөдрөөс эхлэн 2 долоо хоногийн хугацаанд хэрэгжих тус сургалтад зориулан Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчнээс 9 хүний бүрэлдэхүүнтэй баг хүрэлцэн ирсэн. Сургалтад хамрагдах бие бүрэлдэхүүн тэдний туршлага сургаж, мэдлэг чадвараас ихээхэн зүйлсийг сурч авна гэдэгт итгэлтэй байна" гэлээ.



ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНҮҮД ЧУУЛЛАА



Өнөөдөр Төрийн цэргийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтнууд ЗХЖШ-наа чуулж төрийн цэргийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан дэмжлэг үзүүлэх боломж, энхийг дэмжих ажиллагааны оролцооны асуудлаар санал солилцлоо. Хурлыг нээж ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд хэлсэн үгэндээ "Монгол Улсын

Батлан хамгаалах бодлогын үндэс болон бусад хууль, баримт бичгийн дагуу төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэл зэрэг үйл ажиллагааны нэгдмэл бэлэн байдлыг хангах асуудал нь цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага болох ЗХЖШ-ын үүрэг байдгийг онцлоод эл уулзалтаар төрийн цэргийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан дэмжлэг үзүүлэх боломж, энхийг дэмжих ажиллагааны оролцооны асуудлаар санал солилцож, тус тусын

удирдлагууддаа уламжлах зорилтыг тавьж байна" хэмээсэн юм. Хурлын хүрээнд ЗХЖШ-ын АУГ-ын Нэгдсэн ажиллагааны төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Д.Эрдэнэбилэг төрийн цэргийн байгууллагуудын нэгдсэн ажиллагааны талаарх танилцуулгыг хийсэн бол үргэлжлүүлэн төрийн цэргийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтнууд тус тусын байгууллагынхаа гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар нийт бие бүрэлдэхүүнд тайлагналаа.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	☁️ -2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 28

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,488	3,493
EUR 🇪🇺	3,835	3,860
CNY 🇨🇳	510	513.50
RUB 🇷🇺	42,50	42.80
JPY 🇯🇵	26	26.50
KRW 🇰🇷	2.65	2.68

ЗУРХАЙ

2023.04.18 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 28

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
УЛААН МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.58-19.45

Барилдлага:

Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Нэр өнгө

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал цэгц, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 685,740,983

Эдгэрсэн

Нийт: 6,842,948

Нас барсан

Нийт: 6,842,948

Цахим шууданд

“БИД МАНЛАЙЛАГЧ” ЗӨВЛӨГӨӨНД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 6 АНГИЙН ОФИЦЕР, АХЛАГЧ ОРОЛЦОЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Жанжин штабаас 2023 оныг “Залуу офицер, ахлагчийн манлайлын жил” болгон зарласантай уялдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас Зэвсэгт хүчний 167 дугаар ангийг түшиглэн “Бид манлайлагч” хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг Өмнөговь аймагт 4 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Зөвлөгөөн цаашдаа бүсчлэн зохион байгуулагдах ба анхны гарааг нь Өмнөговь аймагт эхлүүлж, Зэвсэгт хүчний 167, 256, 336, 339 дүгээр анги болон Зэвсэгт хүчний 065, 124 дүгээр ангийн тусгай салбарууд, төрийн цэргийн бусад байгууллагын нийт 50 гаруй офицер, ахлагч хамрагдаж байна.

Хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа

Ц.Буяндэлгэр удирдан явуулж байгаа бөгөөд тэрээр “Цэргийн алба нийгмийн манлайлах салбар” илтгэлээр эхлүүлж, Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин П.Цэрэндагва “Хувь хүний хөгжил, төлөвшил”-ийн тухай үргэлжлүүлэн өгүүллээ.

Энэхүү арга хэмжээ нь хоёр үе шаттайгаар буюу “Бид манлайлагч” хэлэлцүүлэг, “Харилцаа хандлага нэмэгдүүлж, сахилга хариуцлага бэхжүүлэх нь” гэсэн хоёр сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа юм. Ялангуяа, гэмт хэргээс урьдчилан сэргийлж, сахилга хариуцлага бэхжүүлэх хүрээнд Нийслэлийн Цагдаагийн удирдах газар болон Өмнөговь аймгийн Цагдаагийн газартай хамтран илтгэл хэлэлцүүлэг өрнүүлж, хувь хүний хөгжил талаас нь тус аймгийн Гэр бүл, хүүхэд,

залуучуудын хөгжлийн газар болон “Насан дүршийн боловсролын төв”-ийн багш нар “Ажлаас халсрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Аз жаргалтай ажилтан, бүтээмжтэй ажилтан”, “Харилцаа ба хандлага” сэдвээр лекц уншиж, дасгал ажил гүйцэтгүүлсэн юм.


Мөн командлалын томилгоот бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсан Цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилт, анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч, Хуурай замын цэргийн командлалын сахилга, дэг журмыг бэхжүүлэх салбар зөвлөлийн зорилго, төлөвлөгөөг танилцууллаа.

Зөвлөгөөн, хэлэлцүүлгийн хүрээнд өдгөө оролцогчдын дунд гар бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулагдаж, ЦДБЭЧ-ын “Military Band” хамтлаг болон Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театр, Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн авьяаслаг алба хаагчдын хамтарсан урлагийн тоглолтыг толилуулах юм.

Харин 4 дүгээр сарын 18-ны өдөр Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн Сургалтын төвд “Бид манлайлагч” зөвлөгөөн, хэлэлцүүлэг хугацаат цэргийн алба хаагчдад үргэлжлэн явагдана.

Хурандаа Ц.Буяндэлгэр Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчидтай “Цэргийн алба-эрх зүйн ухамсар” сэдвээр чөлөөт ярилцлага хийж, Хөдөлмөрийн баатар П.Цэрэндагва “Эр хүн байхын учир” сургамжит яриагаа өрнүүлнэ. Мөн энэ үеэр хугацаат цэргийн алба хаагчдаас сэтгэл зүйн тандалт судалгаа авч, урлагийн мэргэжлийн байгууллагуудын тоглолтыг өргөн барих юм.

ДОКТОР, ПРОФЕССОР БЭЛТГЭЛ ХУРАНДАА Ч.ЭРДЭНЭЧУЛУУН ЛЕКЦ УНШЛАА



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Дэд захирал-Эрдэмтэн нарийн бичгийн дарга асан, доктор (Ph.D), профессор бэлтгэл хурандаа Ч.Эрдэнэчулуун “Нийгмийн шинжлэх ухааны судалгааны өнөө болон орчин үеийн шинэ хандлага” сэдвээр УБХИС-ийн багш, судлаач, магистрант, докторант нарт лекц уншлаа.

Тус лекцэд УБХИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, доктор (Sc.D),

профессор хурандаа Б.Өлзийхуяг, БХЭШХ-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор хурандаа Д.Содномцог болон БХУА, АБС, ЦНДС-ийн багш, судлаач, магистрант, докторант нар оролцов.

Лекцээр монголын нийгмийн судалгааны өнөөгийн байдал, нийгмийн судалгааны олон улсын нийтлэг жишиг, нийгмийн судалгаанд тавигдах шинэ шаардлага, арга зүй, чиг хандлагын талаар ярилцлаа.

БХЭШХ

ЭХ ОРНОО БАТЛАН ХАМГААЛАХ ҮҮРГЭЭ СУРТАЛЧЛАВ



Зэвсэгт хүчний 150 дугаар анги, Сонгинохайрхан дүүргийн гэр бүлзалуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, батлан хамгаалах салбарын бодлого, зорилтыг сурталчлах, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой “Хөвгүүдийн хөгжил-хүчирхийлэлгүй ирээдүй” сэдэвт өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгт Сонгинохайрхан дүүргийн 21-н сургуулийн 1100 гаруй сурагчид хүрэлцэн ирж эрүүл мэнд, хууль зүй, сэтгэл зүй, хүүхэд залуучуудын оролцоо, мэргэжил сонголт гэсэн сэдвийн хүрээнд мэдээ мэдээлэл авсан юм.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 150 дугаар ангиас сурагчдын дунд гар дээр сунгалтын тэмцээн зохион байгуулж, зэвсэг, техникийн үзэсгэлэнгээ дэлгэсний зэрэгцээ гардан тулааны болон жагсаалын үзүүлэх тоглолтоо толилууллаа.

Гардан тулааны үзүүлэх тоглолтод 72 цэргийн алба хаагч, жагсаалын үзүүлэх тоглолтод 32 цэргийн гэрээт алба хаагч, зэвсэг техникийн үзэсгэлэнд 36 цэргийн алба хаагчид оролцон ирээдүй хойч үе болсон дүү нартаа цэрэг эх орноо батлан хамгаалах эрх, үүргээ сурталчилсан юм.

Ахмад Н.ДЭЛГЭРМАА



ЗЭВСЭГТ ХҮЧИНД НЭГДЭХ СОНИРХОЛТОЙ ОЮУТАН ЗАЛУУСТ МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Этүгэн их сургуулийн 2023 оны төгсөгчдийн дунд зохион байгуулсан “Ажил олгогчдын нээлттэй хаалганы өдөрлөг”-т Цэргийн төв эмнэлэг оролцлоо.

Тус өдөрлөгт төр, хувийн хэвшлийн 50 гаруй эмнэлгийн байгууллагууд оролцож Этүгэн их сургуулийг эмнэлгийн мэргэжлээр төгсөж буй 800 гаруй оюутнуудад танилцуулга, нээлттэй ярилцлага хийсэн юм. Энэ үеэр Цэргийн төв эмнэлгээс “Сувилагчийн нээлттэй ажлын байр”-д шинэ төгсөгчдийг урих ажлын хүрээнд 6 албан тушаалтны бүрэлдэхүүнтэй баг ажиллаж цэргийн төв эмнэлэгт болоод Зэвсэгт хүчинд ажиллах хүсэл сонирхолтой оюутнуудаас бүртгэл, анкетыг бүрдүүлэн авлаа.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ ТЕАТРЫН МЭРГЭЖИЛТНҮҮД ЦДБЭЧ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



УГЗ Д.Доржсүрэн Энэхүү уулзалтад даргатай Дундговь ЦДБЭЧ-ын дарга, СГЗ, аймгийн Төв Халхын хурандаа Г.Золзаяа, Дуулалт жүжгийн театрын ССХМА-ны дарга, дэд мэргэжилтнүүд ЦДБЭЧ-ын үйл ажиллагаатай танилцлаа.

Энэхүү уулзалтад ЦДБЭЧ-ын дарга, СГЗ, хурандаа Г.Золзаяа, ССХМА-ны дарга, дэд мэргэжилтнүүд Р.Өнөржаргал, Санхүүгийн албаны дарга-Ерөнхий нягтлан бодогч

Л.Энхзаяа, Нууцын дарга архивын эрхлэгч сургагч ахлагч Н.Хишигжаргал, Дундговь аймгийн Төв Халхын Дуулалт жүжгийн театрын дарга УГЗ Д.Доржсүрэн болон тус театрын мэргэжилтнүүд оролцлоо.

Эл арга хэмжээний хүрээнд Төв Халхын Дуулалт жүжгийн театрын мэргэжилтнүүд архив, урын сан, хүний нөөцийн бичиг баримтыг хэрхэн зөв зохистой бүртгэх, хадгалах, өвлүүлэн үлдээх, төлөвлөлт зохион байгуулалтын бичиг баримт, төлөвлөгөө тайланг хэрхэн үйлдэх, маркетингийн бодлого, контент хөгжүүлэлт, мэдээ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх талаар зөвлөгөө авч санхүүгийн баримт, бүртгэл, шилэн данс зэрэгтэй танилцаж туршлага судаллаа.